



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/26

Цагаан-Овоо

Хязгаарлалтын дэглэмийг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 10.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1, 18 дугаар зүйлийн 18.1, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоол, хорио цээр, хязгаарлалтын дэглэм хэрэгжүүлэх журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Буянт багийн нутаг Эхэн шанд, Шар худаг, Булгийн хүр гэх нутагт гарсан малын гоц халдварт мялзан өвчний хорио цээрийн дэглэмийг цуцалж хязгаарлалтын дэглэмд шилжүүлсэн 14 хоногт малын өвчлөл илрээгүй тул хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Хязгаарлалтын дэглэм цуцалсан ч малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ард иргэд, малчдыг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.ӨЛЗИЙХИШИГ

